

**"ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХ, ОРОЛЦОО, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ
ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ
/Говьсүмбэр аймаг/**

2022.11.20-ны байдлаар

№	Гүйцэтгэхажил, аргахэмжээнийчиглэл	Хэрэгжүүлэх угацаа	Шалгуурзүүлэлт	Хүрэх үр дүн	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	Байгууллагын албан хаагчдын гэр бүлд хөгжлийн бэрхшээлтэй гишүүн байдаг эсэх талаар судалж зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлэх	Судалгааг гаргасан байна.	Байгууллагын албан хаагчдын гэр бүлд хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг эсэх талаарх судалгааг гаргасан. 1 албан хаагчийн гэр бүлд хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн байна. Хэрэгжилт 70%
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн төлөвлөлтийн чиглэлээр инженер, архитекторуудад сургалт зохион байгуулсан байх	II-р улирал, IY-р улирал	Дэд бүтцийн төлөвлөлтийн чиглэлээрх норм, стандарт, хот байгуулалтын баримт бичгийг судалж, нэмэлт өөрчлөлт оруулах асуудалд санал өгөх	Сургалт зохион байгуулсан байна.	1.Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газраас 2022 оны 05 дугаар сард зохион байгуулсан аймаг, нийслэлийн ерөнхий архитекторыг чадавхижуулах сургалтанд БХБХ-ийн дарга хамрагдсан. 2.Явган хүний зам, талбайн төлөвлөлт, техникийн шаардлага MNS 6808:2019, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин үндсэн шаардлага MNS 6055:2009-н дагуу бүтээн байгуулалтын ажил, зам талбайн тохижилт, барилгын орц гарц, ариун цэврийн өрөө зэргийг төлөвлөсөн зураг төслийн дагуу ажлыг гүйцэтгүүлж ашиглалтад оруулах талаар онцгой анхаарч ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар Сүмбэр сумын 2-р багт бичил цэцэрлэгт хүрээлэн, Цагдаагийн хэлтсийн барилга, Сүмбэр сумын 640 хүүхдийн суудалтай барилгын ажлуудад дээрх стандарт шаардлагыг хангуулан ажилласан байна. Хэрэгжилт-80%

3	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулж, албан хаагчийн олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах	Жилдээ	Сургалт, мэдээллийн тоо хэмжээ	Мэдээллээр хангах, сургалт, сурталчилгаа хийсэн байна.	Албан хаагчдыг 2 удаа сургалтад хамруулсан. -Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу Чөлөөт болон танин мэдэхүй сэдэвт сургалтаар 2022 оны 09 сарын 20-ны өдөр албан хаагчдад урьдчилан сэргийлэх талаар сургалтыг зохион байгуулсан байна. - Мөн аймгаас ХАБЭА-н аяны хүрээнд зохион байгуулсан сургалтанд нийт 12 албан хаагчийг хамруулсан. Хэрэгжилт-100%
4	E.gazar.gov.mn-ийг олон нийтэд таниулан, сурталчлах зорилгоор сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан дохионы хэлээр видео мэдээ бэлтгэх	Жилдээ	Мэдээллийн тоо хэмжээ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ хүрсэн байна.	-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээ мэдээллээр хангах, мэдээллийг хүртэх боломжийг нэмэгдүүлэх үүднээс “ Цахим үйлчилгээ-Тэгш хүртээмж ” сэдэвт гарын авлагыг бэлтгэн 520,000 төгрөгийн зардлаар брайль үсгээр хэвлүүлэхээр “Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо” ГҮТББ-тай гэрээ байгуулан захиалга өгсөн. -Мөн 15 төрлийн мэдээ мэдээллийг бэлтгэн уншуулж, дохионы хэлээр давхар уншуулан түгээхээр “Үжин тайж” ТББ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Хэрэгжилт-100 хувь
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөнгөлөлт үзүүлэх талаар мэргэжлийн эрхтэй байгууллагуудад уриалга, чиглэл хүргүүлэх.	Жилдээ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулна.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ахуй, амьдралыг дэмжих	- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхцөл шаардлагыг хангах чиглэлээр барилга байгууламжийн Улсын комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөллийг оролцуулан ажиллаж 3 барилгад хамтран ажилласан байна. - Мөн төрийн байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ХБИ-д ээлтэй орчин бүрдүүлэх талаар тусгах саналыг аймгийн Засаг даргад гарган гэрээнд тусгуулсны дагуу 25 байгууллагын 2022 оны гэрээнд

					тусгайлан заалт оруулсан. Хэрэгжилт-100%
6	Төрийн байгууллагуудын орц гарцыг ХБИ үйлчлүүлэх стандартад нийцүүлэхэд анхаарч шаардлага хүргүүлэх, заавар зөвлөмж өгөх	Жилдээ	Стандартад нийцсэн зам, орц гарцтай байгууллагын тоо нэмэгдсэн байна	Мэдээллээр хангах. Шардлага хүргүүлэх	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заалт тусгуулахаас гадна өөрийн байртай 15 байгууллагад олон улсад нэвтрүүлсэн сайн жишээ, туршлагыг тусгасан хялбаршуулсан гарын авлагыг хүргүүлж ажилласнаас 8 байгууллага тодорхой арга хэмжээнүүдийг авч ажилласан талаар хариу тайлан ирүүлсэн. Тухайлбал: 2 байгууллага налуу зам хийсэн, 1 байгууллага 00 өрөөг засварласан, 2 байгууллага ХБИ авч ажиллуулж байгаа, 1 байгууллага ХБИ-ий булан байгуулж, компьютер, чихэвч, томруулдаг шил, 109 ширхэг сонсдог аудио ном, CD тоглуулагч, сонсдог номын төхөөрөмжүүдийг байгшуулсан, зарим байгууллагууд төсөв зардал шийдүүлэхээр санал өгсөн гэх мэтээр үр дүн гарсаар байна. Хэрэгжилт 100%
Нийт					Хэрэгжилт -91,7%

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР